



ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, 53.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Геронтологийн үндэсний төвийн дүрмийн 4.2.1 тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геронтологийн үндэсний төвийн 2027–2030 оны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөний төслийг байгууллагын мандат, чиг үүрэг, бодлогын баримт бичгийн уялдаа, судалгаа, статистик, нотолгоонд үндэслэн боловсруулж, байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулахад шаардлагатай мэдээлэл, тайлан, судалгаа, санал, дүгнэлтийг тогтоосон хугацаанд ажлын хэсэгт ирүүлж, дэмжлэг үзүүлж ажиллахыг албаны дарга, холбогдох ажилтнуудад үүрэг болгосугай.

4. Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эрүүл насжилт, гериатр, геронтологийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, сэргээн засах тусламж, сургалт, судалгаа, үндэсний хэмжээний арга зүйн дэмжлэг, байгууллагын хүний нөөц, дэд бүтэц, мэдээллийн систем, чанар, аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх чиглэлийг стратеги төлөвлөгөөнд тусган боловсруулахыг ажлын хэсэгт даалгасугай.

5. Ажлын хэсгийн хуралдаан, хэлэлцүүлэг, саналын нэгтгэл, боловсруулсан баримт бичиг, холбогдох материалыг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу бүрдүүлж, хадгалалт, ашиглалт, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Стратеги төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Л.Халиун)-д даалгасугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, сургалт, хөгжлийн албаны дарга (Н.Долгормаа)-д даалгасугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БАТ-УНДРАХ



269066

Геронтологийн үндэсний төвийн захирлын
2026 оны 06 дугаар сарын 09 өдрийн А/65..
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

Захиргаа төлөвлөлт, сургалт хөгжлийн албаны дарга Н.Долгормаа


Нарийн бичиг:

Стратеги төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Л.Халиун

Гишүүд:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний албаны дарга П.Долгоржав
2. Санхүү бүртгэл, дэмжих үйлчилгээний албаны дарга Б.Отгонтэнгэр
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга Ш.Нармандах
4. Төгсөлтийн дараах сургалт, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн С.Гантуяа
5. Хүний нөөцийн менежер Ч.Өнөрцэцэг
6. Ахлах сувилагч М.Отгонжаргал
7. Эрүүл мэндийн даатгал, статистик хариуцсан мэргэжилтэн Н.Эрдэнэсүрэн
8. Эдийн засагч А.Дэлгэрсайхан
9. Мэдээллийн технологийн инженер П.Ганзориг
10. Уламжлалт анагаах ухааных эмч Б.Ууганбаяр
11. Сэргээн засахын их эмч Ч.Загарсүрэн
12. Настан судлалын их эмч Н.Оюунтуяа
13. Халдвар судлаач А.Ёндонжамц

Геронтологийн үндэсний төвийн захирлын
20᠗6 оны ᠒6 дугаар сарын ᠒9. өдрийн А/65.
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Геронтологийн үндэсний төвийн 2023–2026 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа 2026 онд дуусгавар болж байгаатай холбогдуулан байгууллагын хөгжлийн дараагийн үе шатны зорилго, зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон 2027–2030 оны стратеги төлөвлөгөө боловсруулах шаардлага үүсэж байна.

Энэхүү стратеги төлөвлөгөөг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон холбогдох бусад бодлого, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн боловсруулна.

Монгол Улсад хүн амын насжилтын түвшин нэмэгдэж, ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, судалгаа, сургалт, мэргэжил, арга зүйн дэмжлэгийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд Геронтологийн үндэсний төвийн үндэсний хэмжээний чиг үүрэг, хөгжлийн тэргүүлэх чиглэл, байгууллагын чадавх, үйл ажиллагааны үр нөлөөг дунд хугацаанд тодорхойлох стратеги төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Геронтологийн үндэсний төвийн 2027–2030 оны хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон нотолгоонд суурилсан стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулахад оршино.

Гурав. Зорилт

3.1. Байгууллагын чиг үүрэг, эрх зүйн орчин, бодлогын баримт бичгийн уялдаа холбоонд шинжилгээ хийх.

3.2. Байгууллагын хүний нөөц, санхүү, дэд бүтэц, тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх.

3.3. Байгууллагын дотоод болон гадаад орчны шинжилгээ хийж, хөгжлийн тэргүүлэх чиглэл, боломж, эрсдэлийг тодорхойлох.

3.4. Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, стратегийн зорилго, зорилтыг шинэчлэн тодорхойлох.

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

[illegible]

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

мжээ, шалгуур үзүүлэлтүүдэд
гээ, үнэлгээний ерөнхий
а, нэгж, ажилтнууда

№	Үе шат	Хугацаа
1	Бэлтгэл ажил, мэдээлэл цуглуулах	2 долоо хоног
2	Нөхцөл байдал, дотоод болон гадаад орчны шинжилгээ хийх	3 долоо хоног

3	Дотоод болон гадаад орчны шинжилгээ хийх	3 долоо хоног
4	Арга хэмжээ, шалгуур үзүүлэлт боловсруулах	2 долоо хоног
5	Хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авах	1 долоо хоног
6	Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах	1 долоо хоног

Шаардлагатай тохиолдолд ажлын явц, нөхцөл байдлаас хамааран хугацааг ажлын хэсгийн ахлагчийн саналыг үндэслэн зохицуулж болно.

Найм. Гарах үр дүн

8.1. Геронтологийн үндэсний төвийн 2027–2030 оны стратеги төлөвлөгөөний төсөл.

8.2. Байгууллагын нөхцөл байдал, дотоод болон гадаад орчны шинжилгээний тайлан.

8.3. Стратегийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний төсөл.

8.4. Стратеги төлөвлөгөөний төсөлтэй холбоотой санал, хэлэлцүүлгийн нэгтгэл.